



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР
ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ
ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРСЭН БАЙНА**

**АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

**АУДИТЫН КОД:
АРА-2026/05-1/ШТА-НА**



Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор **Т.Байгалмаа**
Утас: 77333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер **Н.Алтантуяа**
Утас: 77332860 Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn
Ахлах аудитор **Г.Цог-Эрдэнэ**
Утас: 99210906 Цахим хаяг: Tsogerdeneg@audit.gov.mn
Аудитор **Н.Энхчимэг**
Утас: 89891150 Цахим хаяг: Enkhchimegn@audit.gov.mn
Аудитор **Н.Дашмягмар**
Утас: 99164665 Цахим хаяг: Dashmyagmarn@audit.gov.mn



Тайлан бэлтгэсэн:	➤ Товчилсон үгийн тайлбар2
Архангай аймаг дахь	➤ Аудитын зорилт, арга, зүй стандартын талаар3-5
Төрийн аудитын газар	➤ Үндсэн мэдээлэл5
	➤ Аудитын тайлан6-19
Тэргүүлэх аудитор	
Т.Байгалмаа	БҮЛЭГ А. ОНТХО-ААР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН ТАХ-НИЙ 74.5 ХУВЬ НЬ АЙМАГ, СУМЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ УЯЛДСАН БАЙНА
Аудитын менежер	А.1. ОНТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээ аймаг, сумын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан төсөвлөсөн байна
Н.Алтантуяа	А.2.ОНТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний 68.6 хувь төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна
Ахлах аудитор	БҮЛЭГ 2. ОНТХО-ААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАХ-НИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА
Г.Цог-Эрдэнэ	Б.1 ОНТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.
Аудитор	Б.2 ОНТХО-аар шинээр хэрэгжүүлсэн ТАХ-ний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулсан байна
Н.Энхчимэг	БҮЛЭГ В. ОНТХО-ААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТАХ НЬ ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРСЭН БАЙНА
Н.Дашмягмар	В.1 ОНТХО-аар 2025 онд төлөвлөсөн санхүүжилтийн 93.8 хувийг олгосон байна
2026 оны 04 дүгээр сар	В.2. ОНТХО-аар хэрэгжүүлсэн 34 ТАХ-ний 80.5 хувьд зохиогчийн болон захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна
Уг тайланг www.audit.mn сайтаас үзнэ үү.	В.3 Тайлант онд хэрэгжсэн 30 ТАХ-г ашиглагч байгууллага нягтлан бодох бүртгэлд тусгаж, зориулалтын дагуу ашиглаж байна.
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах зүйл байвал 7033-2860 дугаарын утас, 7033-3141 дугаарын факсаар харилцана уу	Дүгнэлт..... 19
Хаяг:	Холбогдох байгууллагын санал 20
Архангай аймаг	Тайлан баталгаажуулсан тушаал..... 21-22
ЗДТГ-ын байр	Хавсралт:Судалгаанууд 23-25
3-р давхар 314 тоот	



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчлол	Тайлал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БОНХОТХ	Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн хэлтэс
МУЗГ	Монгол Улсын засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ТАХ	Төсөл арга хэмжээ
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛТИЙН ТОВЬЁГ

Дугаар	Нэр
Хүснэгт 1	ОНТХО-аар 2025 онд хэрэгжүүлэхээр баталсан ТАХ
Хүснэгт 2	ОНТХО-ын 2025 оны төлөвлөгөө, гүйцэтгэл
Хүснэгт 3	ОНТХО-ын 2025 оны жилийн төлөвлөгөөтэй уялдсан байдал
Хүснэгт 4	ОНТХО-ын он дамжин хэрэгжих ТАХ
Хүснэгт 5	Аймгийн ОНТХО хэрэгжсэн ТАХ-ний үнэлгээний хороо байгуулсан байдал
Хүснэгт 6	Сумдын ОНТХО-аар хэрэгжсэн ТАХ-ний үнэлгээний хороо байгуулсан байдал
Хүснэгт 7	ОНТХО-аар 2025 онд хэрэгжсэн ТАХ
Хүснэгт 8	ОНТХО-ын санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэл
Хүснэгт 9	ОНТХО-ын нягтлан бодох бүртгэлд тусгагдах ТАХ
Хүснэгт 10	Аймгийн ОНТХО-аар хэрэгжсэн болон дамжин хэрэгжих ТАХ-ний зорилтот түвшин, бодит ажлын гүйцэтгэл
Хүснэгт 11	Эрдэнэбулган сумын ОНТХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-ний зорилтот түвшин, бодит ажлын гүйцэтгэл
Хүснэгт 12	Өмнөх аудитаар шалгагдагч байгууллагад хүргүүлсэн шийдвэрийн хэрэгжилт
Дүрслэл 1	ОНТХО-ын тендер ХАА зохион байгуулалт
Дүрслэл 2	ОНТХО-ын ажлын даалгавар, зураг төсөвтэй ТАХ



АУДИТЫН НЭР:

“Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”

АУДИТЫН КОД: АРА-2026/05-1/ШТА-НА

АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны “Аудитын сэдэв батлах тухай” 25 дугаар тогтоол, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” МУЕА-ын 2025 оны А/179 дугаар тушаал, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан аудитын төлөвлөгөөг үндэслэн хийлээ.

АУДИТЫН ЗОРИЛТ

Архангай аймгийн орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Үндэсний аудитын газар, аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээ оновчтой төлөвлөсөн эсэх;
- Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж хяналт тавьсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх;

АУДИТЫН ХАМАРСАН ХҮРЭЭ

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон авто замын сангийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлсэн аймгийн ЗДТГ, СТСХ, БОНХОТХ, ГХБХБГ, ХААГ, Эрдэнэбулган, Цэцэрлэг, Батцэнгэл, Хашаат, Хотонт сумын ЗДТГ болон холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагаас хяналт хийсэн ажлын тайланг хамрууллаа.

АУДИТЫН АРГА ЗҮЙ

Аудитад гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа авах зэрэг арга зүйг ашиглав.

АУДИТАД АШИГЛАСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль,



- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Барилгын тухай хууль,
- Авто замын тухай хууль,
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”,
- “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”,
- Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр
- Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай
- ЗГ-ын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”
- Аймгийн ИТХ-ын тогтоолууд
- Архангай аймгийн 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө
- Эрдэнэбулган, Цэцэрлэг, Хашаат, Хотонт, Батцэнгэл сумын Орон нутгийн 2025 оны хөрөнгө оруулалтын жагсаалт /Сумын ИТХ-ын тогтоол/

АУДИТ ХИЙСЭН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Аудитыг Төрийн аудитын газрын Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа хянан удирдаж, аудитын менежер Н.Алтантуяа аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ, аудитор Н.Энхчимэг, Н.Дашмягмар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2026.03.09-2026.05.01-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

АУДИТЫН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, ТҮҮНД ТУСГАХ МЭДЭЭЛЭЛ:

Аудитын тайлан нь аудитын зорилт, дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал болон хавсралт хэсгээс бүрдэнэ.

Гүйцэтгэлийн аудитын тайланг асуудлын шинжилгээний 4 дэх түвшний асуулт бүрд хариулт өгч тэмдэглэгээ хийсэн ба 2,3 дахь түвшний асуултын хүрээнд ерөнхийдөө ангилан бичсэн болно.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Аймгийн ИТХ-ийн 2025 оны 07 дугаар сарын 21-ны өдрийн 06/28 дугаар тогтоолоор аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, авто замын сангаас зарцуулах төсвийг анх баталсан төсвөөс 1,969.9 сая төгрөгөөр бууруулан 6,100.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл, арга хэмжээнд, сумдын тухайд анх баталсан төсвөөс 51.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1,928.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 39 төсөл арга хэмжээнд, нийт 8,029.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 51 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталжээ. Төсвийн тодотголоор Хашаат сум шинээр 13 төсөл арга хэмжээнд 157.5 сая төгрөг, Цэцэрлэг, Хотонт сумд 5 төсөл, арга хэмжээнд 62.5 сая төгрөгийг нэмж баталсан байна.



ОНТХО-аар 2025 онд хэрэгжүүлэхээр баталсан ТАХ

Хүснэгт №1 сая.төгрөг

№	Төсөл арга хэмжээний нэр	Анх баталсан (төсөвт өртөг)		Тодотгосон (төсөвт өртөг)		Өсөлт (+) Бууралт (-)	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	тоо	Мөнгөн дүн
1	Аймгийн ОНТХО	17	6,595.5	11	4,627.9	- 6	- 1,967.6
2	Авто замын сан	1	1,475.3	1	1,473.0	-	- 2.3
	Аймгийн ОНТХО, авто замын сангийн дүн	18	8,070.8	12	6,100.9	- 6	- 1,969.9
3	Эрдэнэбулган сум	13	1,756.2	13	1,588.0	-	- 168.2
4	Хашаат сум	-	-	13	157.5	13	157.5
5	Батцэнгэл	2	25.0	2	25.0	-	-
6	Цэцэрлэг сум	3	47.5	4	82.0	1	34.5
7	Хотонт сум	3	48.0	7	76.0	4	28.0
	Сумын ОНТХО-ын дүн	21	1,876.7	39	1,928.5	18	51.8
	Дүн	39	9,947.5	51	8,029.4	12	- 1,918.1

Эх сурвалж: аймаг, сумдын 2025 оны төсөв баталсан тогтоол

Нийт батлагдсан төсвийн 57.6 хувь буюу 4,627.9 сая төгрөгийг аймгийн ОНТХО-аар хэрэгжих 11 их засварын ажилд, 18.3 хувь буюу 1,473.0 сая төгрөгийг авто замын сангаас хэрэгжих 1 ТАХ-д, 24.1 хувь буюу 1,928.5 сая төгрөгийг 5 суманд хэрэгжих 39 ТАХ-д зарцуулахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр аймгийн ОНТХО-аар 3,257.0 сая төгрөг, авто замын сан 1,152.1 сая төгрөг, сумд 1,591.7 сая төгрөг, нийт **6,000.8** сая төгрөгийн санхүүжилтийг гэрээний дагуу олгосон бөгөөд 2025 оны төлөвлөсөн санхүүжилтийн гүйцэтгэл 89.3 хувьтай байна.

ОНТХО-ын 2025 оны төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №2 сая төгрөг

№	Сумдын нэр	ТАХ-ний тоо	Баталсан төсөв (2025 онд санхүүжих)	Гүйцэтгэл (гүйцэтгэгчид олгосон)	
				тоо	Мөнгөн дүн
1	Аймгийн ОНТХО	11	3,315.3	11	3,257.0
2	Авто замын сан	1	1,152.1	1	1,152.1
	Аймгийн ОНТХО, авто замын сангийн дүн	12	4,467.4	12	4,409.1
	Эрдэнэбулган сум	13	1,588.0	10	1,430.90
2	Хашаат сум	13	157.5	2	31.7
3	Батцэнгэл	2	25.0	1	15
4	Цэцэрлэг сум	4	82.0	2	39.1
5	Хотонт сум	7	76.0	7	75
	Сумын ОНТХО-ын дүн	39	1,928.5	22	1,591.7
	Нийт дүн	51	6,395.9	34	6,000.8

**БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ 74.5 ХУВЬ НЬ АЙМАГ, СУМЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ УЯЛДСАН БАЙНА****А.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээ аймаг, сумын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан төсөвлөсөн байна**

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9¹, Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.2², 63.3³, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.1.4.1⁴ дэх заалтуудыг үндэслэн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө аймаг, сум нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан батлахаар хуульчилсан.

А.1.1. Аймгийн ОНТХО-аар хэрэгжүүлэхээр баталсан 4,627.9 сая төгрөгийн 11 ТАХ нь аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөтэй уялдсан. Мөн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан 1,473.0 сая төгрөгийн ТАХ нь Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3⁵, 24.4⁶ дэх заалттай нийцэж байна. Харин Сумдын ОНТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 39 ТАХ-ний 13 ТАХ нь тухайн сумын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөтэй уялдаагүй байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт №1-ээс харна уу)

ОНТХО-ын ТАХ-ний 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан байдал

Хүснэгт № 3 сая төгрөг

№	Сумдын нэр	Нийт хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний		Аймаг, сумдын 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд				Авто замын тухай хуулийн дагуу		Тусгагдаагүй ТАХ-ний хувь(тоогоор)
				Тусгагдсан ТАХ		Тусгагдаагүй ТАХ				
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	
1	Аймгийн ОНТХО	11	4,627.9	11	4,627.9	-	-	-	-	
2	Авто замын сан	1	1,473.0	-	-	-	-	1	1,473.0	
3	Эрдэнэбулган сум	13	1,588.0	12	1,444.5	1	143.5			7.7%
4	Хашаат сум	13	157.5	8	91.8	5	65.7			38.4%
5	Батцэнгэл сум	2	25.0	2	25.0	-	-			
6	Цэцэрлэг сум	4	82.0	4	82.0	-	-			
7	Хотонт сум	7	76.0			7	76.0			100.0%
	Дүн	51	8,029.4	37	6,271.2	13	285.2	1	1,473.0	25.5%

Хүснэгтээс үзэхэд Эрдэнэбулган, Хашаат, Хотонт сумдын ИТХ аар батлагдсан арга хэмжээнээс 285.2 сая төгрөгийн 13 ТАХ нь жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна.

¹ Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Орон нутгийн төсөв хамаарна.

² Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

³ Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчийн ажлын алба ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Зөвлөлд өргөн мэдүүлнэ.

⁴ хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан болон уялдсан байдал;

⁵ 24.3.Улсын авто замын сангийн хөрөнгөөр олон улс, улсын чанартай авто замын, нийслэл, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр нийслэл, орон нутгийн чанартай авто замын арчлалт, засварын ажлыг тус тус санхүүжүүлнэ.

⁶ 24.4.Авто замын сангийн хөрөнгөөр авто замын арчлалт, урсгал засвар, гэнэтийн хүчин зүйлээс хамаарсан засварын ажлыг тэргүүн ээлжид санхүүжүүлнэ.



Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.4.1⁷ дэх заалттай нийцэхгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Эрдэнэбулган сумын 143.5 сая төгрөгийн 1,
- ✓ Хашаат сумын 65.7 сая төгрөгийн 5,
- ✓ Хотонт сумын 76.0 сая төгрөгийн 7 нийт 13 ТАХ нь сумын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөтэй уялдаагүй байна.

Шийдвэрлэлт: Аудитаас сумын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй ТАХ-г төлөвлөсөн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлагыг Эрдэнэбулган, Хашаат, Хотонт сумын Засаг дарга нарт хүргүүлээ.

А.1.2. Аймгийн Засаг даргаас 2023 онд төрийн өмчийн барилга байгууламжид судалгаа, хяналт шалгалт үзлэг хийх үүрэг даалгавар өгсний дагуу ГХБХБГ-ын даргын 2023 оны 09 сарын 11-ний өдрийн А/51 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг аймгийн 19 сумын 173 барилга байгууламжид үзлэг шалгалт хийж дүгнэлт гарган барилга байгууламжийг үнэлж эрэмбэлсэн байна. Ажлын хэсгийн үнэлгээгээр аймгийн хэмжээнд 57 барилга байгууламжид их засвар, 31 барилгад урсгал засвар, нийт 88 барилга байгууламжид засвар хийх нэгдсэн дүгнэлт гаргаж, суурь судалгааны сантай болсон байна.

Дээрх судалгаанд үндэслэн 2025 онд аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар боловсролын салбарын 2,797.5 сая төгрөгийн 8 ТАХ, соёлын салбарын 403.1 сая төгрөгийн 2 ТАХ, бусад салбарын 114.7 сая төгрөгийн 1 ТАХ, нийт барилгын их засварыг 4,627.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

А.1.3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онд хэрэгжүүлэхээр 1 төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

Аймгийн ОНТХО-аар нийт барилгын их засварын 11, сумд барилга, байгууламжийн 1, их засвар тохижилтын 15, авто зам, дэд бүтцийн 4, тоног төхөөрөмжийн 18, ТЭЗҮ 2 (2024, 2026 он), нийт 51 ТАХ-г төлөвлөсөн байна.

А.1.4. Сумд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө, эрэмбэлэн төлөвлөөгүй байна.

А.2. ОНТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний 68.6 хувь төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна

А.2.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээнд магадлалаар баталгаажуулах шаардлагатай томоохон хөрөнгө оруулалтын ажил төлөвлөгдөөгүй байна.

А.2.2. Сумдад ТЭЗҮ, зураг төсөв, ажлын даалгавар боловсруулаагүй 35 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна

ОНТХО-аар хэрэгжих төсөл, арга хэмжээг сумын ИТХ-д өргөн барьж, батлуулахдаа тухайн шатны Засаг дарга төсөвлөлтийн шаардлагыг хангуулж техник эдийн засгийн үндэслэл зураг, төсөв, эдийн засгийн тооцоо судалгааг хийсэн байхаар хуульчилсан.

Аймгийн 2025 оны ОНТХО-аар хэрэгжүүлэхээр баталсан 4,627.9 сая төгрөгийн 11 ТАХ, авто замын сангийн 1,473.0 сая төгрөгийн ТАХ-ний ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсвийг урьдчилан боловсруулж баталсан байна. Харин сумдад ТЭЗҮ, зураг төсөв, ажлын даалгавар боловсруулаагүй 1,764.5 сая төгрөгийн 35 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь

⁷ "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан болон уялдсан байдал"



Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁸, Барилгын тухай хуулийн 4 зүйлийн 4.1.30⁹ дахь заалттай нийцэхгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Хашаат сум 157.5 сая төгрөгийн 13,
- ✓ Эрдэнэбулган 1,449.0 сая төгрөгийн 11,
- ✓ Цэцэрлэг 82.0 сая төгрөгийн 4,
- ✓ Хотонт сумын 76.0 сая төгрөгийн 7 ТАХ, нийт 35 ТАХ нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна.

Шийдвэрлэлт: Аудитаар Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлага, шалгуур хангаагүй ТАХ-г төлөвлөсөн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлагыг Хашаат, Эрдэнэбулган, Цэцэрлэг, Хотонт сумдын Засаг дарга нарт хүргүүллээ.

A.2.3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээнд санхүүжилтийг хэрэгжих хугацаатай нь уялдуулан олгосон байна.

A.2.4. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 11 төсөл арга хэмжээнээс 1,584.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл арга хэмжээ нь он дамжин хэрэгжүүлэхээр баталсан байна.

ОНТХО-аар он дамжин хэрэгжих төсөл арга хэмжээ

Хүснэгт №4 сая.төгрөг

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа	нийт төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
1	Ерөнхий боловсролын сургуулийн их засвар (Цэцэрлэг сум)	2025-2026	686.8	392.9
2	Ерөнхий боловсролын сургуулийн 80 ортой дотуур байрны их засвар (Өндөр-Улаан сум)	2025-2027	327.0	232.6
3	Ерөнхий боловсролын сургуулийн их засвар (Эрдэнэмандал сум)	2025-2028	570.9	300.0
Дүн			1,584.7	925.5

Эх сурвалж: Аймаг, сумдын 2025 оны төсөв баталсан тогтоол

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА

Б.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

Б.1.1. Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, үнэлгээний хороог хуульд заасан хугацаанд байгуулсан байна

⁸ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана

⁹ "зураг төсөл" гэж барилга байгууламжийг төлөвлөх, барилгын ажил гүйцэтгэхэд шаардагдах загвар зураг, эх загвар зураг /эскиз/, техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зураг, барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын төсөл, инженер хайгуулын судалгаа, инженер геологи, геодезийн зураглал, инженерийн тооцоо, өртгийн төсөв зэрэг баримт бичгийн иж бүрдлийг;



Аймгийн ХААГ нь аймгийн ОНТХО-аар шинээр хэрэгжих 18 ТАХ-ний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2024.12.25-ны өдөр аймгийн Засаг даргаар батлуулан shilendans.gov.mn цахим системд байршуулжээ.

Эрдэнэбулган сум нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 11 ТАХ-ний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг сумын засаг даргаар батлуулан shilendans.gov.mn цахим системд 2025.01.05-ны өдөр байршуулсан байна. Харин бусад сумдын хувьд босго үнэд багтаан шууд худалдан авалт хийхээр төлөвлөсөн байна.

Б.1.2. Аймгийн ИТХ-ын тогтоолоор 2025 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 10 төсөл арга хэмжээний зураг, төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг аймгийн ХААГ-т хүргүүлсэн байна.

Б.1.3. Тендерийн баримт бичигт оролцогчдод тавих шаардлагыг тусгасан эсэхийг үнэлэхэд ТАХ-ний ажлын тоо хэмжээ, онцлог, цар хүрээнд тулгуурлан ерөнхий шаардлага, санхүүгийн чадавхын шаардлага, техникийн чадавх болон туршлагын шаардлага, тусгай зөвшөөрлийн шаардлага зэргийг тендерийн баримт бичигт тусган боловсруулж худалдан авах ажиллагааг зарласан байна.

Б.1.4. Аймаг, сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан нийт 51 төсөл арга хэмжээний, 2 төсөл арга хэмжээ нь өмнөх оноос шилжсэн бөгөөд тайлант онд 33 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 16 төсөл арга хэмжээ нь хэрэгжээгүй байна.

Дүрслэл -1 Тендер ХАА зохион байгуулалт

Нийт 33 ТАХ-ний ХАА-г зохион байгуулахдаа төсөвт өртөгт уялдуулан 42.4 хувь буюу 14 ТАХ-г нээлттэй тендер шалгаруулалтаар, 21.2 хувь буюу 7 ТАХ-г харьцуулалтын аргаар шалгаруулсан бол 36.4 хувийг шууд худалдан авах гэрээ байгуулжээ.

Харин Эрдэнэбулган сум 46.4 сая төгрөгийн 2, Цэцэрлэг сум 29.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2, Батцэнгэл сум 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, Хашаат сум хэрэгжүүлэх 122.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11, нийт 208.1 сая төгрөгийн 16 ТАХ хэрэгжээгүй, худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна. Энэ нь УИХ-аас төсвийн алдагдлыг бууруулах, үүнтэй холбоотойгоор үр ашиг багатай болон нэн шаардлагатай бус орон нутгийн ТАХ-ний зардлыг танасантай холбоотой байна.

Аймгийн ОНТХО, Авто замын сангийн тухайд:

Аймгийн ХААГ нь 2025 оны ХАА-ны төлөвлөгөөний дагуу орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжих 4,930.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2025 онд 3,950.4 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 10 ТАХ-ний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.6¹⁰-д заасны дагуу tender.gov.mn цахим хуудсаар зохион байгуулсан байна.

Үнэлгээний хороо нь нийт шинээр хэрэгжсэн 10 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа 9 ТАХ-г анхны тендер шалгаруулалтаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан, 1 ТАХ-г 4 удаа тендер зарлаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Аймгийн ОНТХО-аар хэрэгжсэн ТАХ-ний үнэлгээний хороо байгуулсан байдал



¹⁰ 45.6-д "Аймаг, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээг энэ хуулийн 45.5-д заасан захиалагч өөрийн хэрэгцээнд худалдан авахаас бусад тохиолдолд тендер шалгаруулалтыг худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын аймаг, нийслэл, дүүрэг дэх нэгж зохион байгуулна"



Хүснэгт №5

ДД	Төсөл, арга хэмжээний нэр	2025 онд санхүүжих дүн /сая төгрөг/	Үнэлгээний хороо байгуулсан огноо	Тендер шалгаруулалт зохион байгуулсан тоо	ХАА-нд мөрдөгдсөн журам
1	Ерөнхий боловсролын сургуулийн их засвар /Архангай аймгийн Цэцэрлэг сум/	392.9	2025.03.27	1	НТШ
2	Хүүхдийн 11 дүгээр цэцэрлэгийн их засвар /Архангай аймгийн Эрдэнэбулган сум/	607.9	2025.04.30	1	НТШ
3	Ерөнхий боловсролын сургуулийн 80 ортой дотуур байрны их засвар /Архангай аймгийн Өндөр-Улаан сум/	232.5	2025.03.27	1	НТШ
4	Соёлын төвийн их засвар /Архангай аймгийн Эрдэнэмандал сум/	156.8	2025.03.27	1	ХА
5	Ерөнхий боловсролын сургуулийн их засвар /Архангай аймгийн Эрдэнэмандал сум/	300	2025.03.27	1	НТШ
6	Ерөнхий боловсролын сургуулийн их засвар /Архангай аймгийн Хотонт сум/	528.7	2025.04.07	1	НТШ
7	Хүүхдийн номын сан, төв номын сангийн их засвар тохижилт /Архангай аймгийн Эрдэнэбулган сум/	246.3	2025.02.21	1	НТШ
8	ЗДТГ-ын байрны засвар / Архангай аймгийн Эрдэнэмандал сум/	114.7	2025.04.07	4	НТШ
9	Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн их засвар /Архангай аймгийн Эрдэнэбулган сум/	218.5	2025.03.27	1	НТШ
10	Цэцэрлэг хотын авто замын засвар шинэчлэл, арчлалт (Цэцэрлэг хот)	1,152.10	2025.04.02	1	НТШ
	Нийт дүн	3,950.4	-	13	-

Сумдын тухайд:

ОНТХО-аар хэрэгжүүлэхээр баталсан 1,562.6 сая төгрөгийн 11 ТАХ-ний худалдан авах ажиллагааг хуульд нийцүүлэн сумдын ЗДТГ-аас зохион байгуулжээ.

Сумдын ОНТХО-аар хэрэгжсэн ТАХ-ний үнэлгээний хороо байгуулсан байдал

Хүснэгт № 6 сая.төгрөг

ДД	Төсөл, арга хэмжээний нэр	2025 онд санхүүжих дүн	Үнэлгээний хороо байгуулсан огноо	Тендер шалгаруулалт зохион байгуулсан тоо	ХАА-нд мөрдөгдсөн журам
1	Шинэ суурьшлын бүсэд цахилгаан хангамж сайжруулах шинэчлэл /Эрдэнэбулган сум /	87.0	2025.05.01	1	ХА
2	Захын бизнес эрхлэгчдийн ажлын байр /Эрдэнэбулган сум /	87.3	2025.05.19	1	ХА
3	5-р сургуулийн өргөтгөлийн зураг төсөв боловсруулах /Эрдэнэбулган сум /	55.0	2024.10.30	1	НТШ
4	ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин /Эрдэнэбулган сум /	143.5	2025.04.17	1	НТШ
5	Хог хаягдлыг ачиж тээвэрлэх автомашин тусгай зориулалтын техник /Эрдэнэбулган сум /	613.0	2025.04.01	1	НТШ



6	Гэр хорооллын хаягжуулалт /Эрдэнэбулган сум /	88.3	2025.05.01	1	ХА
7	Шинэ суурьшлын бүсэд усан сан барих, засвар үйлчилгээ хийх /Эрдэнэбулган сум /	50.0	2025.05.01	1	ХА
8	Гэрэлт цамхаг /Эрдэнэбулган сум /	157.0	2025.04.10	1	НТШ
9	Цахим Архангай хөтөлбөрийн хүрээнд цахим сургалтын тоног төхөөрөмж /Эрдэнэбулган сум /	91.5	2025.04.01	1	ХА
10	1-48-р байрны урд тоглоомын талбай хийх /Эрдэнэбулган сум /	150.0	2025.05.08	1	НТШ
11	Сумын нэгдсэн камержуулалт /Цэцэрлэг сум /	40.0	2025.05.21	1	ХА
	Нийт дүн	1,562.6	-	11	

Сумын ОНТХО-аар шинээр хэрэгжсэн төсөл арга хэмжээнээс 34.8 сая төгрөгийн өртөгтэй 2 ТАХ-г босго үнэд багтаан жижиглэн хувааж баталсныг ЗДТГ-аас тендер зарлалгүйгээр шууд гэрээ байгуулан ажилласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1¹¹, 10.3¹², 10.5¹³, 48 дугаар зүйлийн 48.2.1¹⁴ дэх заалтуудтай нийцэхгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Хашаат сумын ЗДТГ-ын цэвэр бохир шугамын холболт хийх 34.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээг шууд худалдан авах, аргыг хэрэглэх зорилгоор тендер зарлалгүйгээр шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.

Шийдвэрлэлт: Аудитаас худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, зөрчлийг таслан зогсоох албан шаардлагыг Хашаат сумын Засаг даргад хүргүүлээ.

Б.1.5. Тайлант хугацаанд тендер худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажил гүйцэтгэхээр байгуулсан 21 төсөл арга хэмжээнээс 20 төсөл арга хэмжээнд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан ерөнхий шаардлага, санхүүгийн чадавхын шаардлага, техникийн чадавх болон туршлагын шаардлага, тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангасан оролцогчийг шалгаруулсан байна. Харин Эрдэнэбулган сумын “Цахим Архангай хөтөлбөрийн” хүрээнд цахим сургалтын тоног төхөөрөмж нийлүүлэх тендерт шалгарсан “Их-хаан групп” ХХК нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тул захиалагч гэрээг нь цуцалсан байна.

Б.2 ОНТХО-аар шинээр хэрэгжүүлсэн 33 тах-ний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулсан байна

Б.2.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалттай холбоотой Сангийн яаманд гомдол гаргаагүй байна

¹¹ “Захиалагч тендер шалгаруулалтыг энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэгт заасан аргаар зохион байгуулна”

¹² “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”

¹³ “Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно”

¹⁴ “Худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах”



ТБОНӨХБАУХАТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.1¹⁵, 11.2¹⁶-т заасны дагуу аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч шинээр хэрэгжүүлэх 4,930.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ТАХ тус бүрд үнэлгээний хороо байгуулж, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/258 дугаар тушаалаар баталсан “Тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн дагуу ТШӨХ, тендерийн баримт бичгийг боловсруулжээ.

Аймгийн ОНТХО болон авто замын сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалттай холбоотой Сангийн яаманд гомдол гаргаагүй тухай аймгийн ХААГ-аас 2026.04.09-ний 80 дугаар албан бичгээр манайд тайлбарыг ирүүлсэн байна.

Б.2.2. Тендер шалгаруулалттай холбоотой гомдол гараагүй тул шийдвэрлэсэн арга хэмжээ байхгүй болно

Б.2.3. Аймгийн ХААГ-аас 2025 онд оруулсан цахим системийн бүртгэл, мэдээлэлд Төрийн худалдан авах ажиллагааны газраас хяналт, шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй байна

БҮЛЭГ В. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ НЬ ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРСЭН БАЙНА

В.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд төлөвлөсөн санхүүжилтийн 93.8 хувийг олгосон байна

В.1.1. Аймгийн хэмжээнд 2025 онд аймаг, сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, авто замын сангийн хөрөнгөөр нийт 8,029.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 51 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 58.0 хувь буюу 4,655.4 сая төгрөгийн 30 төсөл арга хэмжээ нь бүрэн хэрэгжиж, 38.1 хувь буюу 3,057.7 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ дутуу буюу гэрээгээр он дамжиж, 3.9 хувь буюу 316.3 сая төгрөгийн 17 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

ОНТХО-аар 2025 онд хэрэгжсэн ТАХ

Хүснэгт № 7 сая төгрөг

Сумын нэр	ИТХ-аар батлагдсан ХО, хөтөлбөр, ТАХ-ний		Гэрээ байгуулсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Бүрэн хэрэгжсэн ТАХ-ний		Гэрээгээр он дамжих ТАХ-ний		Огт хэрэгжээгүй ТАХ-ний	
	Тоо	Төсөвт өртөг	тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн	Тоо	Дүн
Аймаг	11	4,627.9	11	4,627.9	8	3,043.2	3	1,584.7	-	-
Авто замын сан	1	1,473.0	1	1,473.0			1	1,473.0	-	-
Эрдэнэбулган сум	13	1,588.0	11	1,446.2	10	1,446.2			3	141.8
Цэцэрлэг сум	4	82.0	2	43.3	2	43.3			2	38.7
Хотонт сум	7	76.0	7	76.0	7	76.0			-	-
Батцэнгэл сум	2	25.0	1	15.0	1	15.0			1	10
Хашаат сум	13	157.5	2	31.7	2	31.7			11	125.8
Дүн	51	8029.4	35	6266.9	30	4,655.40	4	3057.7	17	316.3

Он дамжин хэрэгжих 3 ТАХ нь:

- ✓ Цэцэрлэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын их засвар 686.8 сая төгрөг,
- ✓ Өндөр-Улаан сумын Ерөнхий боловсролын 80 ортой дотуур байрны их засвар барилгын их засвар 327.0 сая төгрөг,

¹⁵ 11.1-д “Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална”

¹⁶ 11.2-д “Оролцогчийг тендер бэлтгэж ирүүлэхэд шаардагдах мэдээлэл, оролцогчид тавих шаардлага, заавар, хамгийн сайн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, тендерийн жишиг маягыг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана”



- ✓ Эрдэнэмандал сумын Ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засвар 570.9 сая төгрөг байна.

Улс орны эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч, төсвийн орлогын төлөвлөгөө тасалдаж, төсөвт тодотгол хийгдэж, санхүүжилтийг эрхийг хязгаарласантай холбоотой 316.3 сая төгрөгийн 17 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Хашаат сум нь төсвийн тодотголоор 13 ТАХ-г төлөвлөснөөс зөвхөн 2 ТАХ хэрэгжсэн нь ТАХ-ний хэрэгжилтийн хувь буурахад голлох нөлөө үзүүлсэн байна.

В.1.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд үндэслэн олгосон байна

Аймаг, сумдын ОНТХО, авто замын сангийн хөрөнгөөр 34 ТАХ-нд нийт 6,000.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

ОНТХО-ын санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт № 8 сая төгрөг

Аймаг, сумын нэр	2025 онд санхүүжих дүн		Гэрээний дүн		Нийт олгосон санхүүжилт	
	ТАХ тоо	Мөнгөн дүн	ТАХ тоо	Мөнгөн дүн	ТАХ тоо	Мөнгөн дүн
Аймаг	11	3,315.3	11	4,627.9	11	3,257.0
Автозамын сан	1	1,152.1	1	1,473.0	1	1,152.1
Аймгийн дүн	12	4,467.4	12	6,100.9	12	4,409.1
Эрдэнэбулган сум	13	1,588.0	11	1,537.6	10	1,431
Цэцэрлэг сум	4	82.0	2	43.3	2	39.1
Хотонт сум	7	76.0	7	76.0	7	75.0
Батцэнгэл сум	2	25.0	1	15.0	1	15.0
Хашаат сум	13	157.5	2	31.7	2	31.7
Сумын дүн	39	1,928.5	23	1,703.6	22	1,591.7
Нийт дүн	51	6,395.9	35	7,804.5	34	6,000.8

Аймгийн ОНТХО-аар хэрэгжсэн 11 ТАХ-нд 3,257.0 сая төгрөг, авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжих 1 ТАХ-нд 1,152.1 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгож, 58.3 сая төгрөгийг техник хяналтын зардлыг хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлжээ.

Авто замын сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний санхүүжилтийг гэрээний дагуу гүйцэтгэлийг бүрэн олгосон бөгөөд 320.9 сая төгрөг нь дараа онд олгох санхүүжилт байна.

Сумын ОНТХО-аар 5 суманд 1,591.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 ТАХ ангиллаар авч үзвэл:

- Их засвар тохижилт 396.2 сая төгрөгийн 10 ТАХ,
- Машин, тоног төхөөрөмж 1,008.6 сая төгрөгийн 9 ТАХ,
- ТЭЗҮ 54.0 сая төгрөгийн 1 ТАХ,
- Барилга байгууламж, дэд бүтэц 132.9 сая төгрөгийн 2 ТАХ тус тус байна.

Аудитын илрүүлэлт:

- Эрдэнэбулган сум “Захын жижиглэнгийн бизнес эрхлэгчдийн ажлын байр”-ны тохижилтыг гүйцэтгэсэн “Цэн-Ар ХХК-д 1.1 сая төгрөгийн илүү санхүүжилтийг олгосон,
- Эрдэнэбулган сум “Шинэ суурьшлын бүсэд Усан сан барих” ажлыг гүйцэтгэсэн Архангай ус суваг ОНӨААТҮГ-т 0.4 сая төгрөгийн илүү санхүүжилт олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар




хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт, тайлагнах журам"-ын 2.3.4-т¹⁷ гэсэн заалтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Илүү олгосон санхүүжилтийг орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоож, Эрдэнэбулган сумын Засаг даргад хүргүүлэв.

В.1.3. Аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалт, авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 34 төсөл арга хэмжээнээс бүрэн ашиглалтад оруулсан 30 төсөл арга хэмжээг батлагдсан зураг төсөв, ажлын даалгаврын дагуу гүйцэтгүүлж, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэн, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын актаар хүлээн авсан байна.

Ажлын даалгавар, зураг төсөвтэй ТАХ

Дүрслэл-2



В.1.4. Аймаг, сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 30 төсөл арга хэмжээг комиссын үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авч, гэрээг дүгнэж ажилласан байна

Аймгийн ОНТХО-аар хэрэгжүүлсэн их засварын ажлуудаас

Зураг-1



¹⁷ Төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын үе шатуудад холбогдох мэдээлэл, баримт бичгийн иж бүрдлийг цахим системд оруулж, албан бичгээр баталгаажуулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх бөгөөд тэдгээрийн иж бүрэн, үнэн зөв байдлыг бүрэн хариуцан ажиллах



В.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний 80.5 хувьд зохиогчийн болон захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгийн оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5 зүйлийн 5.3.1¹⁸, 5.3.3¹⁹-т заасны дагуу төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа төсөл арга хэмжээнд захиалагчийн болон зохиогчийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж байгууллага хяналт тавьж, цаашид авах хэмжээг зохион байгуулан ажиллахаар заасан байна.

В.2.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 7 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн ОНТХО-аар хэрэгжсэн 11 ТАХ, Эрдэнэбулган сумын 10 ТАХ-нд зураг төсөв, ажлын даалгаврын дагуу захиалагч байгууллагыг төлөөлж, аймгийн ГХБХБГ болон Эрдэнэбулган Цахилгаан түгээх станц ТӨХК-ний хяналтын инженер хяналтыг хэрэгжүүлж ажилласан бол 4 сумын 5 ТАХ-д захиалагч байгууллага буюу сумын ЗДТГ-аас захиалагчийн үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ашиглагч байгууллагад гүйцэтгэлийн баримт бичгийг хүлээлгэн өгчээ. Харин 1 сум захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн ОНТХО-аар хэрэгжүүлсэн 11 их засварын ажилд “Маргад оюу бюлдинг” ХХК, “Дэлийн хотгор” ХХК нь зураг зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж гэрээний дагуу нийт 24.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Аудитын илрүүлэлт:

- Хотонт сумын ОНТХО-аар хэрэгжсэн 76.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 7 ТАХ-ний үе шатны ажлын гүйцэтгэлд захиалагч байгууллагаас хяналтыг огт хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн дугаар зүйлийн 37.1.19-д “Барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, фото зургаар баримтжуулан, ил, далд ажлын актыг баталгаажуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Аудитаас ажлын гүйцэтгэлийн хуваарь гаргаж, үе шатны хяналт хэрэгжүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх байх албан шаардлагыг Хотонт сумын Засаг даргад хүргүүллээ.

В.2.2. Барилгын материалын лабораторийн хүчин чадал хангалтгүйгээс Барилга байгууламжийн заслын ажлын материалын шаардлагад хяналт хийгдээгүй байна

Аймгийн хэмжээнд барилга угсралтын ажлын ТАХ-нд барилгын материалын лабораториор бетоны сорьц, бетоны орц найрлага, тоосго, хөөсөнцөр, хүрмэн гулдмай, явган замын талбайн хавтан, бродюр зэрэгт сорилт шинжилгээ хийж дүгнэлт гаргаж байгаа хэдий ч химийн, хуванцар хаалга, цонх, металл эдлэхүүн, будгийн хэмжилт хийх тоног төхөөрөмжийн байхгүй байгаагаас шалтгаалан дүгнэлт гаргах боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.

Үүнээс шалтгаалан барилгын гадна болон дотор заслын ажлын эмульс, будаг, хуванцар хаалга, цонх нь хүний эрүүл мэнд сөргөөр нөлөөлөх эсэх, зураг төсвийн хийгдсэн эсэхийг үнэлэх боломжгүй байна. / УТХО-ын аудитын тайланд зөвлөмжөөр тусгагдсан /

В.2.3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд комиссын гишүүд заавар журмын дагуу хяналт тавьж, үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад хүлээн авсан байна

¹⁸ Захиалагч болон захиалагчийг төлөөлж захиалагчийн техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага нь төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ;

¹⁹ Захиалагч нь барилга байгууламжийн ажлын үе шат бүрд зохиогчоор хяналт тавиулж, дүгнэлт гаргуулна;



Аудитын илрүүлэлт:

Аймгийн ОНТХО-аар 2024–2025 онд хэрэгжүүлсэн Хашаат сумын Ерөнхий боловсролын сургуулийн “Спорт заал, дотуур байрны их засвар”-ын ажлын гүйцэтгэлд шалгалт хийхэд, 104.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг хүлээн авснаас хойш дусаал дусаж, шороо тоос ордог, хана таазанд нэвчилт үүссэн зэрэг зөрчил илэрсэн байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.3.1²⁰, 5.3.2²¹ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1.4²² дэх заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Аудитаас хөрөнгө оруулалтын ажлыг чанаргүй, дутуу гүйцэтгэсэн гүйцэтгэгчид мэдэгдэл хүргүүлэн холбогдох арга хэмжээг авч, зөрчлийг арилгах албан шаардлагыг ГХБХБГ-т хүргүүлээ.

В.3 Тайлант онд хэрэгжсэн 30 төсөл арга хэмжээг ашиглагч байгууллага нягтлан бодох бүртгэлд тусгаж, зориулалтын дагуу ашиглаж байна

Аймаг, сумдын ОНТХО-аар 2025 онд аймаг 3,043.2 сая төгрөгийн 8 ТАХ, 5 сумын 22 ТАХ, нийт 1,612.2 сая төгрөг, нийт 4,655.4 сая төгрөгийн хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авч, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-н дагуу бүртгэл тайландаа тусгаж ажиллажээ.

ОНТХО-ын нягтлан бодох бүртгэлд тусгагдах ТАХ

Хүснэгт №9 сая төгрөг

ДД	Төсөл арга хэмжээний нэр	Ашиглалтад хүлээн авсан ТАХ	
		Тоо	Мөнгөн дүн
1	Аймгийн ОНТХО	8	3,043.2
2	Эрдэнэбулган сум	10	1,446.2
3	Хашаат сум	2	31.7
4	Хотонт сум	7	76.0
5	Батцэнгэл сум	1	15.0
6	Цэцэрлэг сум	2	43.3
Дүн		30	4,655.4

В.3.2 Төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг батлагдсан шалгуур үзүүлэлтэд үндэслэн тооцож, үр дүнд хүрсэн эсэхийг харьцуулан тайлагнаж үнэлүүлсэн байна

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны хэрэгжилт”, “Архангай аймгийн хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт” үр дүнг холбогдох шалгуур үзүүлэлтэд үндэслэн үнэлж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд нэгтгэн тайлагнажээ.

²⁰ "Захиалагч болон захиалагчийг төлөөлж захиалагчийн техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага нь төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ",

²¹ "Захиалагч болон захиалагчийг төлөөлж захиалагчийн техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага нь барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах,

²² заасан нөхцөл байдал илэрсэн бол холбогдох мэдээллийг эрх бүхий улсын байцаагчид хүргүүлэх зэрэг арга хэмжээг тухай бүр авч ажиллана" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.



Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 08/44 дүгээр тогтоолоор аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг “Үр дүнтэй” гэж дүгнэсэн байна.

В.3.3 Аймаг, сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээ нь зорилтот үр дүнд хүрсэн байна

Аймгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 12 ТАХ-ны гүйцэтгэлээс 9 ТАХ бүрэн хэрэгжсэн 100 хувь, гэрээгээр он дамжсан 3 ТАХ 50–79 хувийн гүйцэтгэлтэй байна. Аудитаар тооцсон нийт ажлын гүйцэтгэлийн дундаж 89.9 хувьтай байна.

Аймгийн ОНТХО-аар хэрэгжсэн болон дамжин хэрэгжих ТАХ-ний зорилтот түвшин, бодит ажлын гүйцэтгэл

<i>Хүснэгт №10</i>			
№	Төсөл, арга хэмжээний нэр	Аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгасан зорилтот түвшин	Аудитаар тооцсон 2025 оны бодит ажлын гүйцэтгэл /хувиар/
1	Ерөнхий боловсролын сургуулийн 320 хүүхдийн хичээлийн байр, спорт заалны их засвар /Архангай аймгийн Хашаат сум/	100%	100%
2	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр, спорт заалны их засвар /Архангай аймгийн Өлзийт сум/	100%	100%
3	Ерөнхий боловсролын сургуулийн их засвар /Архангай аймгийн Цэцэрлэг сум/	100%	100%
4	Хүүхдийн 11 дүгээр цэцэрлэгийн их засвар /Архангай аймгийн Эрдэнэбулган сум/	100%	100%
5	Ерөнхий боловсролын сургуулийн 80 ортой дотуур байрны их засвар /Архангай аймгийн Өндөр-Улаан сум/	50%	50%
6	Соёлын төвийн их засвар /Архангай аймгийн Эрдэнэмандал сум/	100%	100%
7	Ерөнхий боловсролын сургуулийн их засвар /Архангай аймгийн Эрдэнэмандал сум/	50%	50%
8	Ерөнхий боловсролын сургуулийн их засвар /Архангай аймгийн Хотонт сум/	100%	100%
9	Хүүхдийн номын сан, төв номын сангийн их засвар тохижилт /Архангай аймгийн Эрдэнэбулган сум/	100%	100%
10	ЗДТГ-ын байрны засвар /Архангай аймгийн Эрдэнэмандал сум/	100%	100%
11	Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн их засвар /Архангай аймгийн Эрдэнэбулган сум/	100%	100%
12	Цэцэрлэг хотын авто замын засвар шинэчлэл, арчлалт /Цэцэрлэг хот/	100%	79%
Нийт дүн		91.6%	89.9%

Эрдэнэбулган сумын ОНТХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-ний зорилтот түвшин, бодит ажлын гүйцэтгэл

<i>Хүснэгт №11</i>			
№	Төсөл, арга хэмжээний нэр	Эрдэнэбулган сумын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгасан зорилтот түвшин	Аудитаар тооцсон 2025 оны бодит ажлын гүйцэтгэл /хувиар/
1	Шинэ суурьшлын бүсэд цахилгаан хангамж сайжруулах шинэчлэл /Эрдэнэбулган сум /	100%	100%



2	Захын бизнес эрхлэгчдийн ажлын байр /Эрдэнэбулган сум /	100%	100%
3	5-р сургуулийн өргөтгөлийн зураг төсөв боловсруулах /Эрдэнэбулган сум /	100%	100%
4	Хог хаягдлыг ачиж тээвэрлэх автомашин тусгай зориулалтын техник /Эрдэнэбулган сум /	100%	100%
5	Гэр хорооллын хаягжуулалт /Эрдэнэбулган сум /	100%	100%
6	Шинэ суурьшлын бүсэд усан сан барих, засвар үйлчилгээ хийх /Эрдэнэбулган сум /	100%	100%
7	Гэрэлт цамхаг /Эрдэнэбулган сум /	100%	100%
8	Цахим Архангай хөтөлбөрийн хүрээнд цахим сургалтын тоног төхөөрөмж /Эрдэнэбулган сум /	100%	100%
9	1-48-р байрны урд тоглоомын талбай хийх /Эрдэнэбулган сум /	100%	100%
Нийт дүн		100%	100%

Бусад сумдын тухайд 166.0 сая төгрөгийн 12 ТАХ-г бүрэн хэрэгжүүлсэн байна

ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ 96.6 ХУВЬТАЙ БАЙНА.

Өмнөх аудитаар аймаг, Эрдэнэбулган, Жаргалант, Хашаат, Цэцэрлэг, Хайрхан сумын ИТХ, Засаг дарга, аймгийн Засаг дарга, ГХБХБГ, ХААГ, ОНӨГ-т хүргүүлсэн 30 албан шаардлагын хэрэгжилтийг энэ удаагийн аудитаар давтан шалгахад Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г ОНТХО-ын төлөвлөгөөнд тусгаж баталсан зөрчил давтагдсан байна.

*Өмнөх аудитаар шалгаагдагч байгууллагад хүргүүлсэн шийдвэрийн хэрэгжилт
Хүснэгт №12 сая.төгрөг*

№	Байгууллагын нэр	Шалгаагдагч байгууллагад хүргүүлсэн		Хэрэгжсэн		Хэрэгжээгүй	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Цэцэрлэг ИТХ	1	-	1	-	-	-
2	Эрдэнэбулган сумын ИТХ	1	-	1	-	-	-
3	Жаргалант сумын ИТХ	1	-	1	-	-	-
4	Хашаат сумын ИТХ	1	-	1	-	-	-
5	Хайрхан сумын ИТХ	1	-	1	-	-	-
6	Аймгийн Засаг даргай	2	8.3	2	8.3	-	-
7	ХААГ	1	363.7	1	363.7	-	-
8	ОНӨГ	1	360.4	1	360.4	-	-
9	Эрдэнэбулган сумын ЗДТГ	2	381.5	2	381.5	-	-
10	Жаргалант сумын ЗДТГ	3	396.9	3	396.9	-	-
11	Хашаат сумын ЗДТГ	4	278.2	3	181.5	1	96.7
12	Хайрхан сумын ЗДТГ	4	184.9	4	184.9	-	-
13	Цэцэрлэг сумын ЗДТГ	2	119.4	2	119.4	-	-
14	ГХБХБГ	5	1,670.1	5	1,670.1	-	-
15	ХААГ	1	363.7	1	363.7	-	-
Дүн		30	4,127.1	29	4,030.4	1	96.7



Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ОНТХО-аар хэрэгжүүлэхээр баталсан нийт ТАХ-ний 74.5 хувь нь хөгжлийн аймаг, сумын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөтэй уялдсан байна
- ОНТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт ТАХ-ний 68.6 хувь төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна
- ОНТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.
- ОНТХО-аар шинээр хэрэгжүүлсэн ТАХ-ний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулсан байна
- ОНТХО-аар 2025 онд төлөвлөсөн санхүүжилтийн 93.8 хувийг олгосон байна
- Аймаг, сумын ОНТХО-аар хэрэгжүүлсэн 34 ТАХ-ний 80.5 хувьд зохиогчийн болон захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна
- Тайлант онд хэрэгжсэн 30 ТАХ-г ашиглагч байгууллага нягтлан бодох бүртгэлд тусгаж, зориулалтын дагуу ашиглаж байна.

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаас **“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРСЭН БАЙНА ”** гэсэн ерөнхий дүгнэлтийг өгөөд байна.

Аудитын дүн: Аудитаар нийт 2,266.1 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 2,264.6 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх 10 албан шаардлага, 1.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож холбогдох албан тушаалтнуудад хүргүүлээ.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ ТАЙЛБАР:



**АРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139
Утас/Факс: (976) 7033 3231,
Цахим шуудан: info@arkhangai.gov.mn,
Цахим хуудас: www.arkhangai.gov.mn

2026.05.01 № 01/647
танай _____-ны № _____-т

**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө
оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнтэй
танилцлаа.

Тайлбар саналгүй болно.



Б.ЦЭРЭННАДМИД

652600500245



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 11/13

Эрдэнэбулган сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/175 тушаалын гуравдугаар хавсралтын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжийн дагуу “Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2.Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3.Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд боловсруулж, зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Б.Цэрэннадмид)-д үүрэг болгосугай.

4.Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, аймгийн Засаг дарга болон ИТХ-ын дарга нарт хүргүүлэхийг ахлах аудитор (Г.Цог-Эрдэнэ)-д даалгасугай.

5.Аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Г.Цог-Эрдэнэ), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг эрх зүйч аудитор (Б.Анхтуяа)-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Тэргүүлэх аудиторын 2026 оны 05 сарын 01 өдрийн АИБ тоот тушаалын хоёрдугаар хавсралт

"Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн аудитын зөрчлийн нэгтгэл
Аудитын код: ГНАГ-2026/05-01-ШТА-ГА

№	Утга	Хүргүүлсэн шийдвэрийн				Хэрэгжилтийг хариуцах	
		Мөнгөн дүн /мянган төгрөг/	Тоо	Дугаар	Шийдвэр	Байгууллага, албан тушаал	Албан тушаалтны нэр
1	Эрдэнэбулган сумын ОНТХО-аар гүйцэтгэсэн "Захын жижиглэнгийн бизнес эрхлэгчдийн ажлын байр"-ын засварын ажлыг гүйцэтгэсэн Цэн-Ар ХХК-д 1,096.1 мянган төгрөг, Шинэ суурьшлын бусад Усан сан барих засвар ажлыг гүйцэтгэсэн Архангай ус суваг ОНБААТҮГ-т 430.3 мянган төгрөг нийт 1,526.4 мянган төгрөгийн илүү санхүүжилтийг тооцож олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт, тайлагнах журам"-ын 2.3.4-т "Төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын үе шатуудад холбогдох мэдээлэл, баримт бичгийн иж бүрдлийг цахим системд оруулж, албан бичгээр баталгаажуулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх бөгөөд тэдгээрийн иж бүрэн, үнэн зөв байдлыг бүрэн хариуцан ажиллах" гэсэн заалттай нийцэхгүй байна.	1,526.40	1	95	Төлбөрийн акт	Эрдэнэбулган Засаг дарга	Т.Ганзориг
2	Сумын ИТХ-ын 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 06 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт "Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт"-аар Тамгын газрын цэвэр бохир шугамын холболт хийх 34,800.0 мянган төгрөгийн өртөгтэй 2 төсөл арга хэмжээг босго үнэд багтаан жижиглэн хувааж баталсныг ЗДТ-аас төндөр зарлалгүйгээр шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д "Захиалагч төндөр шалгаруулалтыг энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэгт заасан аргаар зохион байгуулах", 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 10.5-д "Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцаж болно", 48 дугаар зүйлийн 48.2.1-д "Худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах", Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолын 2-т "Энэ тогтоолын хавсралтаар тогтоосон төсөвт өртгийн дээд хязгаарыг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөж ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах захиалагч нарт, ... даалгасугай" гэж заасныг тус зөрчсөн байна.	34,800.00	1	360	Албан шаардлага	Хашаат Засаг дарга	Н.Анхбаатар
3	Архангай аймгийн Хашаат сумын ИТХ-ын 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 06 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар эдийн засгийн тооцоолол, зураг төсөв, ажлын даалгаваргүй 157,500.0 төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана" гэсэн заалтыг зөрчсөн байна.	157,500.00	1	361	Албан шаардлага	Хашаат Засаг дарга	Н.Анхбаатар
4	Хашаат сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 65,700.0 мянган төгрөгийн 5 төсөл арга хэмжээний нь сумын 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна. Энэ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.4-т "Засаг дарга сум, дүүргийн түвшинд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдааг хангах, үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих" Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянаж, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.4.1-т "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгит тусгагдсан болон үйлдсэн байдал" гэсэн заалтын зөрчсөн байна.	65,700.00	1	362	Албан шаардлага	Хашаат Засаг дарга	Н.Анхбаатар
5	Аймгийн ОНТХО-аар 2024-2025 онд хэрэгжүүлсэн Хашаат сумын "Ерөнхий боловсролын сургуулийн 230 хүүхдийн хичээлийн байр, спорт заалны их засварын ажлыг "Цагаан сүмбэр" ХХК гүйцэтгэн их засварын ажлыг бүрэн дуусгаж ашиглаж байгууллагад хүлээлгэн өгсөн байна. Засварын ажлын гүйцэтгэлийг газар дээр нь ажлын даалгаврын дагуу тулган шалгахад спорт заалны шал ховхорсон, дээрээс дусаал гоожсон дулаан алдагдалтай ихтэй зэрэг зөрчил илэрсэн байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянаж, тайлагнах журам"-ын 5 дугаар зүйлийн 5.3.1-т "Захиалагч болон захиалагчийг төлөөлж захиалагчийн техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага нь төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ", 5.3.2-т "Захиалагч болон захиалагчийг төлөөлж захиалагчийн техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага нь барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1.4-т заасан нөхцөл байдал илэрсэн бол холбогдох мэдээллийг эрх бүхий улсын байцаагчид хүргүүлэх зэрэг арга хэмжээг тухай бүр авч ажиллана" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.	104,116.70	1	363	Албан шаардлага	ГХБХБГ	Ч.Отгонжаргал



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

6	Эрдэнэбулган сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 143,500.0 мянган төгрөгийн 1 төсөл арга хэмжээний нь сумын 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна. Энэ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.4-т "Засаг дарга сум, дүүргийн түвшинд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдааг хангах, үйл ажиллагааг зохицуулах хэрэгжилтэд хяналт тавих" Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.4.1-т "Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан болон уялдсан байдал" гэсэн заалтыг зөрчсөн байна.	143,500.00	1	364	Албан шаардлага	Эрдэнэбулган Засаг дарга	Т.Ганзориг
7	Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ИТХ-ын 2025 оны 07 дүгээр сарын 30-ны өдрийн 06 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар эдийн засгийн тооцоолол, зураг төсөв, ажлын даалгаваргүй 1,449,000.0 төгрөгийн төсөвт өртөлтэй 11 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана" гэсэн заалтыг зөрчсөн байна.	1,449,000.00	1	365	Албан шаардлага	Эрдэнэбулган Засаг дарга	Т.Ганзориг
8	Хотонт сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 76,000.0 мянган төгрөгийн 7 төсөл арга хэмжээний нь сумын 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна. Энэ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.4-т "Засаг дарга сум, дүүргийн түвшинд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдааг хангах үйл ажиллагааг зохицуулах хэрэгжилтэд хяналт тавих" Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.4.1-т "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан болон уялдсан байдал" гэсэн заалтын зөрчсөн байна."	76,000.00	1	366	Албан шаардлага	Хотонт Засаг дарга	П.Батжаргал
9	Архангай аймгийн Хотонт сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлсэн 76,000.0 төгрөгийн 7 төсөл арга хэмжээнд захиалагчийн үе шатны болон байнгын хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт, тайлагнах журам"-ын 5.3.6-д "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна", 5.3.7-д "Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй барилга байгууламж, их засварын ажил бүрийг биечлэн хянаж, шалгах үүрэг бүхий захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээд нь хяналт хийсэн тухай бүр тэмдэглэл үйлдэж гүйцэтгэгч байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар, түүний биелэлтийн талаар тэмдэглэж ажлын гүйцэтгэлд хаасаргах, их засварын ажил дууссаны дараа санхүүжилтийн баримт бичгийн хамт захиалагчийн архивд "хадгалуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.	76,000.00	1	367	Албан шаардлага	Хотонт Засаг дарга	П.Батжаргал
10	Архангай аймгийн Хотонт сумын ИТХ-ын 2025 оны 07 дүгээр сарын 30-ны өдрийн 06 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар эдийн засгийн тооцоолол, зураг төсөв, ажлын даалгаваргүй 76,000.0 төгрөгийн төсөвт өртөлтэй 7 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана" гэсэн заалтыг зөрчсөн байна.	76,000.00	1	368	Албан шаардлага	Хотонт Засаг дарга	П.Батжаргал
11	Архангай аймгийн Цэцэрлэг сумын ИТХ-ын 2025 оны 07 дүгээр сарын 29-ны өдрийн 03 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар эдийн засгийн тооцоолол, зураг төсөв, ажлын даалгаваргүй 82,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөлтэй 4 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана" гэсэн заалтыг зөрчсөн байна.	82,000.00	1	369	Албан шаардлага	Цэцэрлэг Засаг дарга	Э.Пүрэв-очир
	Төлбөрийн акт	1,526.40	1				
	Албан шаардлага	2,264,616.70	10				
	Нийт дүн	2,266,143.10	11				



ХАВСРАЛТ №1 ОНТХО-аар хэрэгжсэн төсөл арга хэмжээ Аймаг, сумын урт, дунд, богино хугацааны мөрийн хөтөлбөрийн уялдаа

Д Д	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	2025 онд санхүүж их дүн	Аймаг, сумын Засаг даргын 2024- 2028 оны үйл ажилла ааны хөтөлбө р	Аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө	Хэрэгжилтийн хувь	Төлөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-ны	
							Тоо	Мөнгөн дүн
1	Ерөнхий боловсролын сургуулийн их засвар /Архангай аймгийн Цэцэрлэг сум/	686.8	392.9	2.12.4	2.1.1.5	100%		
2	Хүүхдийн 11 дүгээр цэцэрлэгийн их засвар /Архангай аймгийн Эрдэнэбулган сум/	608.0	607.9	2.12.4	2.1.1.5	100%		
3	Ерөнхий боловсролын сургуулийн 80 ортой дотуур байрны их засвар /Архангай аймгийн Өндөр-Улаан сум/	327.0	232.5	2.12.4	2.1.1.5	100%		
4	Соёлын төвийн их засвар /Архангай аймгийн Эрдэнэмандал сум/	156.8	156.8	3.6.5	1.1.1.4	100%		
5	Ерөнхий боловсролын сургуулийн их засвар /Архангай аймгийн Эрдэнэмандал сум/	570.9	300.0	2.12.4	2.1.1.7	100%		
6	Ерөнхий боловсролын сургуулийн их засвар /Архангай аймгийн Хотонт сум/	528.7	528.7	2.12.4	2.1.1.1 1	100%		
7	Хүүхдийн номын сан, төв номын сангийн их засвар тохижилт /Архангай аймгийн Эрдэнэбулган сум/	246.4	246.3	3.6.5	1.1.1.5	100%		
8	ЗДТГ-ын байрны засвар / Архангай аймгийн Эрдэнэмандал сум/	114.8	114.7	3.6.5	9.1.2.1 1	100%		
9	Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн их засвар /Архангай аймгийн Эрдэнэбулган сум/	218.6	218.5	2.12.4	2.1.1.5	100%		
10	Ерөнхий боловсролын сургуулийн 320 хүүхдийн хичээлийн байр, спорт заалны их засвар /Архангай аймгийн Хашаат сум/	680.0	272.7	2.12.4	1.1.1.5	100%		
11	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр, спорт заалны их засвар /Архангай аймгийн Өлзийт сум/	490.0	243.7	2.12.4	1.1.1.4	100%		
Аймгийн ОНТХО-ын нийт дүн		4,627.9	3,315.3	-	-		-	
12	Шинэ суурьшлын бүсэд цахилгаан хангамж сайжруулах шинэчлэл	87.0	87.0	1.4.2.2	3.19.1	100%		
13	Захын бизнес эрхлэгчдийн ажлын байр	87.3	87.3	2.7.1	3.15.1	100%		
15	ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин	143.5	143.5	-	-	0%	1	143.5
16	Хог хаягдлыг ачиж тээвэрлэх автомашин тусгай зориулалтын техник	613.0	613.0	6.4.5	3.19.1	100%		
17	Гэр хорооллын хаягжуулалт	88.3	88.3	5.1.6	3.1.5	100%		
18	Шинэ суурьшлын бүсэд усан сан барих, засвар үйлчилгээ хийх	50.0	50.0	3.9.3	3.11.2	100%		
19	Гэрэлт цамхаг	157.0	157.0	1.4.2.2	3.19.1	100%		
20	Цахим Архангай хөтөлбөрийн хүрээнд цахим сургалтын тоног төхөөрөмж	91.5	91.5	6.4.5	3.19.1	100%		
21	1-48-р байрны урд тоглоомын талбай хийх	150.0	150.0	2.1.5	3.8.2	100%		
22	ТЭЗҮ зураг төсөв	16.4	16.4	2.12.1	3.10.6	100%		
23	Хог хаягдлыг ачиж тээвэрлэх автомашин тусгай зориулалтын техник	19.0	19.0	6.4.5	3.19.1	100%		
24	Газрын хэсэгчилсэн төлөвлөгөө	30.0	30.0	3.6.1	3.1.1	100%		
Эрдэнэбулган сумын нийт дүн		1,588.0	1,588.0				1	143.5
25	ЗДТГ-ын албан хаагчдын тоног төхөөрөмж (Хотонт сум)	18.0	18.0			0%	1	18.0
26	Сургуулийн үдийн цайны хөргүүрийн тоног төхөөрөмж (Хотонт сум)	10.0	10.0			0%	1	10.0
27	Хүүхдийн цэцэрлэгийн хөргүүрийн тоног төхөөрөмж (Хотонт сум)	3.0	3.0			0%	1	3.0
28	ЗДТГ-ын ерөөний засвар (Хотонт сум)	20.0	20.0			0%	1	20.0
29	Сумын төвийн зам засвар (Хотонт сум)	5.0	5.0			0%	1	5.0
30	Өндөр санд багт цамхагт гэрэлт суурилуулах (Хотонт сум)	10.0	10.0			0%	1	10.0
31	Сургуулийн гадна талбайн хашаажуулалт (Хотонт сум)	10.0	10.0			0%	1	10.0
Хотонт сумын нийт дүн		76.0	76.0				7	76.0
32	Цайдам баг авдрант хог цэвэрлэгээ	9.0	9.0			0%	1	9.0
33	Баруун худгийн эрүүл ахуйн бүс тогтоох	12.0	12.0	3.9.24	12.1	100%		
34	Сургуульд шалгалтын материал унших машин худалдан авах	7.5	7.5	2.13.34	2.1	100%		
35	Бичиг хэргийн тоног төхөөрөмж	9.0	9.0				1	9.0



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

36	Хурдан морины өндөр хэмжигч	7.7	7.7				1	7.7
37	Тамгын газрын цэвэр холбох	17.3	17.3	3.11.2	11.1	100%		
38	Бохирын шугам холбох	17.5	17.5	3.11.2	11.1	100%		
39	Тамгын газарт гүний худаг байгуулах	20.0	20.0	3.11.2	11.1	100%		
40	Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт	20.0	20.0				1	20
41	Ногооны талбайд худгийн барилга	7.0	7.0	3.10.1	6.1.2	100%		
42	Сумын төвийн нэгдсэн хог цэвэрлэгээ	20.0	20.0				1	20
43	Мотор өсгөгч /5багт/	7.5	7.5	2.6.3	9.3	100%		
44	Камержуулалт	3.0	3.0	4.3.4	12.3	100%		
Хашаат сумын нийт дүн		157.5	157.5				5	65.7
45	Сумын төвийн камер засварлах, шинэчлэх	15.0	15.0	2.1.5	3.5.2	100%	-	-
46	Хөндлөн булгийн худгийн смарт карт болгох засварлах	10.0	10.0	2.2.6	3.7.10	100%	-	-
Батцэнгэл сумын нийт дүн		25.0	25.0					
47	Сумын нэгдсэн камержуулалт	40.0	40.0	2.1.9	4.2.7	100%	-	-
48	ЗДТГ-ын уурын зуухны засвар	13.0	13.0	2.10.9	3.5.6	100%	-	-
49	Хужиртын рашаан дээр тогны дэд бүтэц шийдвэрлэх	15.0	15.0	4.10.2	2.6.4	100%	-	-
50	Тоног төхөөрөмж	14.0	14.0	1.10.3	3.4.9	100%	-	-
Цэцэрлэг сумын нийт дүн		82.0	82.0	-	-	-		
51	Цэцэрлэг хотын авто замын засвар шинэчлэл, арчлалт (Цэцэрлэг хот)	1,473.0	1,152.1	1.3.1	3.5.1	100%		
Автозамын нийт дүн		1,473.0	1,152.1	-	-	-	-	-
Нийт дүн		8,029.4	6,395.9	-	-	-	13	285.2

ХАВСРАЛТ №2 Орон нутгийн 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний жагсаалт

№	Төсөл, арга хэмжээний нэр	2025 онд санхүүж их дүн	Гүйцэтгэгч байгууллагын нэр	Гэрээний үнийн дүн	Олгосон санхүүжилт
1	Ерөнхий боловсролын сургуулийн 320 хүүхдийн хичээлийн байр, спорт заалны их засвар (Хашаат сум)	272.8	Цагаан сүмбэр ХХК	680.0	268.2
2	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр, спорт заалны их засвар (Өлзийт сум)	243.8	Цагаан сүмбэр ХХК	490.0	239.6
3	Ерөнхий боловсролын сургуулийн их засвар (Цэцэрлэг сум)	392.9	Маргад оюу бюлдинг ХХК	686.8	386.3
4	Хүүхдийн 11 дүгээр цэцэрлэгийн их засвар (Эрдэнэбулган сум)	608.0	Эсгэл ХХК	608.0	597.7
5	Ерөнхий боловсролын сургуулийн 80 ортой дотуур байрны их засвар (Өндөр-Улаан сум)	232.6	Гурантамир ХХК	327.0	226.6
6	Соёлын төвийн их засвар (Эрдэнэмандал сум)	156.8	Уужим цамхаг ХХК	156.8	154.2
7	Ерөнхий боловсролын сургуулийн их засвар (Эрдэнэмандал сум)	300.0	Маргад оюу бюлдинг ХХК	570.9	293.1
8	Ерөнхий боловсролын сургуулийн их засвар (Хотонт сум)	528.7	Гурантамир ХХК	528.7	519.8
9	Хүүхдийн номын сан, төв номын сангийн их засвар тохижилт (Эрдэнэбулган сум)	246.4	Маргад оюу бюлдинг ХХК	246.4	243.6
10	ЗДТГ-ын байрны засвар (Эрдэнэмандал сум)	114.8	Маргад оюу бюлдинг ХХК	114.8	112.8
11	Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн их засвар (Эрдэнэбулган сум)	218.6	Уужим цамхаг ХХК	218.6	214.9
12	Шинэ суурьшлын цахилгаан хангамж сайжруулах 10/0.4КВ-ын АТП-452 дэд станцын чадал ихэсгэх, 0.4 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын шинэчлэл сайжруулалт (Эрдэнэбулган сум)	87.0	Анкерхаус ХХК	86.8	84.2
13	Гэр хорооллын хаягжуулалт (Эрдэнэбулган сум)	88.3	Тод тунгалаг тэмдэг ХХК	88.3	86.7
14	5-р сургуулийн өргөтгөлийн зураг төсөв (Эрдэнэбулган сум)	55.0	Гранд тех ХХК	54.0	54.0
15	Захын жижиглэнгийн бизнес эрхлэгчдийн ажлын байр (Эрдэнэбулган сум)	87.3	Цэн-Ар ХХК	87.2	87.5
16	Хог хаягдлын ачиж тээвэрлэх автомашин, тусгай зориулалтын техник худалдан авах (Эрдэнэбулган сум)	613.0	Арби элеваторс ХХК	612.7	612.7
17	1-48-р байрны урд тоглоомын талбай хийх (Эрдэнэбулган сум)	150.0	Эсгэл ХХК	150.0	143.4
18	Шинэ суурьшлын бүсэд Усан сан барих засвар үйлчилгээний (Эрдэнэбулган сум)	50.0	Архангай ус суваг ОНӨААТҮГ	49.6	48.7
19	Гэрэлт цамхаг (Эрдэнэбулган сум)	157.0	Оджи од ХХК	156.0	152.0
20	ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин (Эрдэнэбулган сум)	143.5	Дунди ХХК	143.5	143.5
21	Цахим Архангай хөтөлбөрийн хүрээнд цахим сургалтын тоног төхөөрөмж (Эрдэнэбулган сум)	91.5	Их хаан групп ХХК	91.4	-
22	Хог хаягдлын ачиж тээвэрлэх автомашин, тусгай зориулалтын техник худалдан авах (Эрдэнэбулган сум)	19.0	Арби элеваторс ХХК	18.2	18.2



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

23	ТЭЗҮ зураг	16.4	-	-	-
24	Газрын хэсэгчилсэн төлөвлөгөө	30.0	-	-	-
25	Сумын нэгдсэн камержуулалт /Цэцэрлэг сум /	40.0	Хишиг Төгөлдөр ХХК	37.3	37.3
26	ЗДТГ-ын уурын зуухны засвар /Цэцэрлэг сум /	13.0	Ш.Мөнхбат	6.0	1.8
27	Хужиртын рашаан дээр тогны дэд бүтэц шийдвэрлэх /Цэцэрлэг сум /	15.0	-	-	-
28	Тоног төхөөрөмж /Цэцэрлэг сум /	14.0	-	-	-
29	ЗДТГ-ын албан хаагчдын тоног төхөөрөмж /Хотонт сум/	18.0	БА БА УЛТИМЭТ ТРЕЙД ХХК	18.0	18.0
30	Сургуулийн үдийн цайны хөргүүрийн тоног төхөөрөмж /Хотонт сум/	10.0	Иргэн Г.Нямсүрэн	10.0	10.0
31	Хүүхдийн цэцэрлэгийн хөргүүрийн тоног төхөөрөмж /Хотонт сум/	3.0	Арина ХХК	3.0	2.0
32	ЗДТГ-ын өрөөний засвар /Хотонт сум/	20.0	Иргэн Г.Отгонцэрэн	20.0	20.0
33	Сумын төвийн зам засвар /Хотонт сум/	5.0	Иргэн Ж.Бадрах	5.0	5.0
34	Өндөр санд багт цамхагт гэрэлт суурилуулах /Хотонт сум/	10.0	Иргэн Д.Давааням	10.0	10.0
35	Сургуулийн гадна талбайн хашаажуулалт /Хотонт сум/	10.0	Иргэн Э.Гэрэлт мандах	10.0	10.0
36	Сумын төвийн камер засварлах, шинэчлэх /Батцэнгэл сум	15.0	Ай-Ти-Эс-Эс ХХК	15.0	15.0
37	Хөндлөн булгийн худгийн смарт карт болгох засварлах /Батцэнгэл сум /	10.0	-	-	-
38	Цайдам баг авдрант хог цэвэрлэгээ /Хашаат сум/	9.0	-	-	-
39	Баруун худгийн эрүүл ахуйн бүс тогтоох /Хашаат сум/	12.0	-	-	-
40	Сургуульд шалгалтын материал унших машин худалдан авах /Хашаат сум/	7.5	-	-	-
41	Бичиг хэргийн тоног төхөөрөмж /Хашаат сум/	9.0	-	-	-
42	Хурдан морины өндөр хэмжигч /Хашаат сум/	7.7	-	-	-
43	Тамгын газрын цэвэр холбох /Хашаат сум/	17.3	Иргэн А.Төгөлдөр	14.2	14.2
44	Бохирын шугам холбох /Хашаат сум/	17.5	Иргэн А.Төгөлдөр	17.5	17.5
45	Тамгын газарт гүний худаг байгуулах /Хашаат сум/	20.0	-	-	-
46	Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт /Хашаат сум/	20.0	-	-	-
47	Наадмын талбайд худгийн барилга /Хашаат сум/	7.0	-	-	-
48	Сумын төвийн нэгдсэн хог цэвэрлэгээ /Хашаат сум/	20.0	-	-	-
49	Мотор өсгөгч /5багт/ /Хашаат сум/	7.5	-	-	-
50	Камержуулалт /Хашаат сум/	3.0	-	-	-
51	Цэцэрлэг хотын авто замын засвар шинэчлэл, арчлалт (Цэцэрлэг хот)	1,152.1	ЛМДШ ХХК	1,473.0	1,152.1
	Дүн	6,395.9	-	7,804.5	6,000.8

